



# Өөрчлөлтийн онол

Рэймонд Жервейс  
2022



---

## Агуулга

Сэдвийн хүрээнд:

- ❖ Өөрчлөлтийн онол нь хэрхэн Үр дүнд суурилсан удирдлагын төлөвлөлтийн процесийн чухал хэсэг болсныг **тайлбарлах**
- ❖ Өөрчлөлтийн онолыг илэрхийлэх, түүнийг тодорхойлох талаар илүү **гүнзгий ойлголт** өгөх.

## Өөрчлөлтийн онол: Онол ба практик

- Өөрчлөлтийн онол нь хөтөлбөр [эсвэл төсөл] хэрхэн, яагаад ажиллах ёстойг тодорхойлсон **таамаглал** (хэрэв тэгвэл ингэнэ логик дээр үндэслэсэн), эрсдэл, гадаад хүчин зүйлсийн цогц ойлголт юм. Энэ нь хөтөлбөрийн үйл ажиллагааг хүлээгдэж буй урт хугацааны үр нөлөөтэй нь холбодог. Энэ нь хөтөлбөрийн [эсвэл төслийн] загварт суурилагдсан бөгөөд ихэвчлэн хөтөлбөрийн [эсвэл төсөл боловсруулах багийн] **мэдлэг, туршлага**, судалгаа, үнэлгээ, шилдэг туршлага, сургамж дээр суурилдаг.
- Өөрчлөлтийн онол нь төлөвлөлтийн явцад бүлгүүд болон оролцогч талууд урт хугацааны зорилгоо боловсруулж, тэдгээр зорилгод хүрэхийн тулд ямар нөхцөл бүрдүүлэх ёстойг тодорхойлдог **нарийн тогтсон оролцоонд суурилсан** үйл явц юм. Эдгээр нөхцөлийг хүссэн үр дүн болгон загварчлах, учир шалтгааны хүрээнд системчлэх явдал юм. Тухайлбал, логик загварын ялгаатай төрлүүд гэх мэтээр.

## Өөрчлөлтийн онолоос ямар үр ашиг бий болох вэ?

“Нийгмийн томоохон өөрчлөлтийг хэрэгжүүлэх нь нэлээд урт хугацаа шаардагдах нарийн төвөгтэй ажил юм. Илүү сайн, эрх тэгш нийгэм, эрүүл нийгмийг бий болгоход тодорхой бус, бүрхэг, санаанд оромгүй саад тотгорууд чөдөр тушаа болдог. Хүлээгдэж буй өөрчлөлт юу байж болох талаар эргэцүүлэн бодоход хэцүү байж болох байгууллагууд, баг бүлэг, түншүүд хамтдаа хаана, хэзээ, хэрхэн, яаж өөрчлөлт бий болох талаар хүчин чармайлт гаргаж оролцсоноор ашиг тус хүртдэг. Өөрчлөлтийн онолыг хөгжүүлэх нь бүлгүүдэд дараах зүйлийг хийхэд тусална:

- Сэтгэлгээнд томоохон өөрчлөлт гарна;
- өөрчлөлт хэрхэн гарах талаар тэдний бодол сэтгэлгээг сайжруулна;
- оролцогч талуудын эрх мэдлийн ялгааг илүү сайн таньж, шийдвэрлэх;
- зорилгодоо хүрэхийн тулд тэгш байдлыг дэмжих;
- өөр өөр оролцогчдын хүлээлт, үүрэг роль, хувь нэмрийг илүү сайн ойлгох;
- цаг хугацаа, нөөцийг хаана зарцуулахаа илүү сайн ойлгох; and
- стратегиа илүү сайн хэмжих.”

Эх сурвалж: The Annie E. Casey сан. Өөрчлөлтийн онолийг бий болгох нь: Практик зөвлөмж. Нэгдүгээр хэсэг

## Өөрчлөлтийн онолыг бий болгох боломжит алхамууд

Алхам 1: Зорилго болон таамаглалаа тодорхойл  
 Алхам 2: Стратеги болон үйл ажиллагаагаа тодорхойл  
 Алхам 3: "Тодорхойгүй байдал"-ийг багасга: стратегийг үр нөлөө болон зорилготой холбох  
 Алхам 4: Завсарлага ав, бүтэн зургаар нь хараад үз

Эх сурвалж: The Annie E. Casey сан.  
 Өөрчлөлтийн онолыг бий болгох нь: Практик зөвлөмж. Хоёрдугаар хэсэг.

Step 1: Нөхцөл байдлын дүн шинжилгээ  
 Step 2: Зорилтот бүлгүүд  
 Step 3: Нөлөөлөл  
 Step 4: Үр нөлөө  
 Алхам 5: Үйл ажиллагаа  
 Алхам 6: Өөрчлөлтийн механизмууд  
 Алхам 7: Дэс дараалал  
 Алхам 8: Өөрчлөлтийн онолын зураглал  
 Алхам 9: Оролцогч талууд ба боломжит хүчин зүйлс  
 Алхам 10: Таамаглал

Эх сурвалж: James Noble. Өөрчлөлтийн онолыг арван алхмаар. NPC

## Товч алхамууд

- 1. Урт хугацааны **зорилго** оо тодорхойлох.
- 2. Зорилгодоо хүрэхэд шаардлагатай **урьдчилсан нөхцөл**ийг тодорхойлохын тулд "хойноос нь урагш зураглах" хэрэгтэй.
- 3. Эдгээр урьдчилсан нөхцөлийг бүрэлдүүлэх та бүхний авч хэрэгжүүлэх **үйл ажиллагааг** тодорхойлох.
- 4. Үйл ажиллагааны гүйцэтгэл үнэлэхэд ашиглах урьдчилсан нөхцөл бүрд **шалгуур үзүүлэлт** боловсруулах.
- 5. Онолын хэсэг тус бүрийг **нэгтгэсэн тайлбар** бичнэ.

*Эх сурвалж: Erin Harris. Өөрчлөлтийн онолын танилцуулга. Харвардын гэр бүлийн судалгааны төсөл*

• “Баярлалаа”



In partnership with  
**Canada**



Mongolia:  
Enhancing Resource  
Management through  
Institutional Transformation

**Address:** Floor 3, National Times News Tower Khudaldaanii gudamj, Khoroo 1  
Chingeltei district, Ulaanbaatar-15160 Mongolia

**Phone:** 7610-5000